

“МОНГОЛД ҮНДЭСНИЙ ГААЛИЙН АЛБА БАЙГУУЛАГДСАН НЬ”

Д.Дашдулам

Монгол улсын их сургууль, Нийгмийн шинжлэх ухааны сургууль. Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: Олноо өргөгдсөн Богд Хаант улсын үед анхны Гаалийн яамыг байгуулжээ. Энэ нь шинэ тулгар улсын хөрөнгө санхүүгийн бодлогод нэн шаардлагатай алба байсныг хэлэх хэрэгтэй. Шинээр байгуулагдсан яам нь тусгай дүрэм, журмыг батлан чандлан мөрдүүлэх болжээ. Уг дүрмээр гаалийн татвар хураах төрөл, хэмжээ, торгуулийн талаар тодорхой заасан байдаг.

Түлхүүр үг: Олноо өргөгдсөн Монгол Улс, Гаалийн яам, Сангийн яам, Журганы газар, пиу, тамга, пайз, тусгай тэмдэгт бичиг, худалдаа

Туурга тусгаар улс Монгол улсыг 1911 онд дахин сэргээн мандуулж, Монголын шарын шашны тэргүүн наймдугаар богд Жавзандамба хутагтыг Монгол улсын хаанд “Шашин төрийг хослон баригч “хаан” цолтойгоор өргөмжлөн их ёслолыг үйлдэж оны цолыг “Олноо өргөгдсөн” хэмээн тунхагласан юм. Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улсын засгийн газрыг анх таван яамтайгаар байгуулан тусгаар тогтнолоо хамгаалан бэхжүүлэх, үндэсний цэргийн хүчнийг бүрэлдүүлж гадны халдлагаас сэрэмжлэх, улсын төсөв, хөрөнгийг эмхлэх зэрэг ажлуудыг хариуцах сангийн яам, шүүх яам, гадаад яам, цэргийн яам, дотоод яамдуудыг байгуулжээ. Энэхүү өгүүлэлдээ Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улсын мөнгө, санхүүгийн бодлогын чухал эх сурвалж болох гаалийн албыг үүсгэн хөгжүүлсэн талаар өгүүлье.

Олноо өргөгдсөний хоёрдугаар он зуны тэргүүн сарын шинийн хоёронд Сангийн яамнаас Богд хаанд өргөн уламжилсан бичигтээ: “Гаалийн хэргийн чухлыг дурдаад, гаалийн хэргийг тусгайлан эрхлэх газар байгуулж, Дотоод яам, Гадаад яам, Сангийн яамны сайдуудын дотроос нэг, нэг хүн гаргаж, гаалийн хэргийг ерөнхийлөн шийтгэх тамга цутган олгож тусгайлан эрхлүүлбэ”¹ гэсэн байдаг. Богд хаанаас гааль хураах нь олон улсын тогтсон хэв хууль мөний тул зарлиг гуйсан ёсоор болгоё хэмээн лүндэн буулгажээ. Ингээд зарлиг ёсоор гаалийн хэргийг ерөнхийлөн шийтгэгч яамыг 1912 оны зуны тэргүүн сарын шинийн найманд байгуулж сайд, түшмэд, бичээч, зарлага гэсэн орон тоотойгоор анх байгуулжээ. Гаалийн яамыг туурга тусгаар улс орноо тунхагласны дарааханаас байгуулж, гадаад улс орнуудаас хараат бусаар бие даасан бодлогыг хэрэгжүүлэх болсон төдийгүй Манжийн эрхшээлд байх үеийн бүх дүрэм, журмыг халж, шинээр гаалийн албыг үүсгэн байгуулсан нь ихээхэн ач холбогдолтой зүйл болсон юм.

Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улсын гаалийн яам байгуулахдаа Сангийн яамнаас эд зүйл авч, гэр барьж албан ажлаа эрхлүүлжээ. 1913 он гэхэд Сангийн яамны зүүн этгээдэд тусгай байшин, хашаатай болж, Богд хааны лүндэнгээр зарлигдсан шүтээн тэргүүтнийг өвлийн тэргүүн сарын шинийн нэгэнд шинэ байрнаа залж, шүтэн тахих болжээ. Гаалийн хэргийг шийтгэх яам нь нэгдүгээрт, аливаа хэргийг ерөнхийлөн шийтгэх яам нь нэгдүгээрт, аливаа гаалийн хэргийг ерөнхийлөн шийтгэх хоёрдугаарт, олон харьяат газрын хүргэж ирэх гаалийг эрхлэн шийтгэн хурааж, дотоод хүүд шилжүүлэх гуравдугаарт, бүх гаалийн хэмжээг шударга төвшин болгох, магадлан байцаах үүрэг хүлээжээ. Богд хааны зарлигаар анхны Гаалийн яамны сайдад анх Бишрэлт засаг бэйлийн хошуу бэйс, Сангийн яамны дэд сайд Доржцэрэнг тохоон томилжээ. Тус яам нь Улиастай, Хиагт, Маймаа, Нийслэл хүрээ, Баруун, Зүүн гаалийн хороо зэрэг салбар газруудтай төдийгүй аймгуудад олон хошуу суурин газруудтай, тэдгээр нь гаалийн татвар, түрээс хураах, тэмдэгт бичиг олгох албуудаар дамжуулан гүйцэтгэж байжээ.

Гаалийн яам нь улс орныхоо санхүүг арвижуулах, гадаад, дотоод худалдааг өргөжүүлэх зэрэг улсын төсөвт үлэмж их хувь нэмэр оруулж байсан ажээ. Гаалийн яам нь гаальд хураасан бүх мөнгийг арван хувь болгож, есөн хувийг сангийн яамнаа хүргүүлж,

¹ Монгол Улсын ҮТТА.Фонд А.8., Д.1, ХН.,3

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

нэг хувийг гаалийн ямны ажилчдын цалин тэтгэвэр, тус яаманд хэрэглэгдэх түлээ мод, ус, бичиг хэрэглэлийн авахад зарцуулж байжээ. Гаалийн яам нь "Хүрээний гаалийн хороо, баруун гаалийн хороо зүүн гаалийн хороонд хуваагдаж"² байжээ.

Хүрээний гаалийн хороо нь гаалийн хэргийг ерөнхийлөн шийтгэгч сайд Бишрэлт бэйл Доржцэрэн, туслцан шийтгэлцэх түшмэл гүн Сү, дэс түшмэл Цэрэндорж, эх зохиох түшмэл Шагдаржав, линхэнэ бичээч Дашдаваа, туслах бичээч Юндэндорж, хаалган дарга Лэгцэг, зарлага Тогтох нарын зэрэг нийт хорин таван хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж, тэдэнд сар бүр тогтосон цалин, тэтгэвэр олгох бөгөөд Сайдын түлээ, ус, лаа, цаасны үнэ зэрэгт бүгд найман зун тавин дөрвөн лан найман цэн зоосон мөнгө, цаасан мөнгө нэг мянга хоёр зуун хорин есийг зарцуулдаг байжээ.

Баруун хороод, Баруун хорооны жинхэнэ түшмэл Буян-Очир, туслах түшмэл Дашням, туслах түшмэл Залгамжит, хятад бичиг байцаан үзэх түшмэл Балсан, жинхэнэ бичээч Намсрай, туслах бичээч Бадамдоной, зарлага Жамц, галч Чүлтэм зэрэг нийт арван долоон хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд тэдгээрийн цалин тэтгэвэр, түлээ, ус, цаас, бийрны зардалд хоёр зуун наян нэгэн лан дөрвөн цэн зоосон мөнгө, дөрвөн зуун хорин нэгэн цаас, наян зургаан мөнгө зарцуулдаг байжээ.

Зүүн хороонд зүүн хорооны жинхэнэ түшмэл Нэринпунцаг, туслах түшмэл тайж Луузандоной, жинхэнэ бичээч Алтангэрэл, туслах бичээс Түмэнбаяр, хэлмэрч Зундуй, зарлага тайж Борхүү галч Цэрэнжав, нарын нийт арван хүний бүрэлдэхүүнтэй, бөгөөд эдгээрийн цалин тэтгэвэрт сард, дөрвөн зуун гучин лан, таван цэн зарцуулдаг байсан байна. Дээрх хороодуд, нийслэл хүрээний Гаалийн яам зэрэг холбогдох газрууд нэгдсэн данс үйлдэн цэс бичиг Богдод айлтгахад, Богд уг нугалбарт улаан бийрээр цохолт хийдэг байв. Монгол оронд үндэсний гаалийн алба байгуулагдсанаар гадаадын худалдаачдаас хураах, дотоодын худалдаачдаас хураах, болон газар болон байгалийн баялаг ашигласны, гар урчууд жижиг үйлдвэрлэгчдээс тус, тус гааль хураах журамтай байжээ.

Монголын үндэсний гаалийн алба үүссэн нь улсын санхүүгийн бодлого, улсын төсөвт ихээхэн ач холбогдолтой зүйл болсон юм. Гаалийн яамнаас авах гаалийн хураамжийг цэгцлэх орилгоор "Гаалийн дүрэм"-ийг боловсруулжээ. Манжийн эрхшээлд байх үед Манжаас гаргасан тусгай дүрмээр гааль хураадаг байв. Уг дүрмээр,

-Орлогын таван хэвийн гааль татвар авах

-Халхад очиж худалдаа арилжаа хийх хятад иргэд заавал Бээжинд ирж, өөрийн биеэр журганы газраас тусгай тэмдэгт бичиг авах журамтай байжээ.

-Уг тэмдэгт нь битгийг нэг жилийн хугацаатайгаар өгөх ба нэг пиу нь арван хүн, хорин тэрэг ачаатай гара эрхийн бичиг ажээ.

-Зохих хураамж олж пиу авсан худалдаачдыг Хаалган, Хөх хотын бүгдийн даргын яам болон бусад газар шалган пиутай нь тулган зохих гааль хураан гаргадаг"³ байжээ.

-Пиуны хугацаа дууссан хойно Гадаад Монголын Төрийг Засах Явдлын яаманд хураалгах ёстой байжээ. Мөн 1878 онд худалдааны шинэ дүрэм зохион баталжээ. Уг дүрэм нь халх монголд хятадын мөнгө хүүлэх худалдааны талаар манжийн төрөөс баримтлах үндсэн бодлогыг тодорхойлж байжээ. 1816 онд нийтлүүлсэн Гадаад Монголын Төрийг Засах Явдлын яамны хууль зүйлийн бичигт энэхүү уг дүрмийг "Хүрээ, Хиагт, Уиастан дөрвөн аймагт худалдаа хийхээр явах худалдааны иргэдийг ялган салгах хууль хэмжээ тогтоогоод үүрд дагаж явуулах нь" нэртэйгээр оруулжээ.

Уг дүрэмд Үүнээс хойш худалдааны иргэдийг урьдын ёсоор Цахар хошууны сайд Хөх хотын мэрэнгийн занги, Долон нуурын хамт мэдэрч (хамаарч Д.Д) яамнаас журганы тэмдэгт бичгийг авахуултугай.

² УТТА.Фонд А.8., Данс. ХН., 11.

³ М.Санждорж "Халхад ятадын мөнгө хүүлэгч худалдаа хөгжсөн нь" УБ.1963.73 дахь тал

Харъяат яамнаас тэмдэгт бичиг олгохдоо харъяат худалдааны хүний нэр овог, худалдах барааны тоо, худалдаа хийхээр очих газар, мордох өдрийг тодорхой хуудас бичиж, журганы бичиг дор нааж, тамга дарж олгосугай.

Тэмдэгт бичиг олгосон хойно даруй зааж очих газрын амбас түшмэдийн яаманд мэдтүгэй хэмээн бичиг явуулна.

Журганы тэмдэгт бичиг аваагүй байвал журганы тэмдэгт бичиггүйн хуулиар шийтгэсүгэй.

Дөрвөн аймгийн хошуудад худалдаа хийхээр очигсодыг халхын засагууд байцаатугай зэрэг нийт арван гурван зүйл бүхий заалттай дүрэм, хэмжээг тогтоожээ.

Уг дүрмээс үзэхэд халхад хулгайн худалдаа хийлгэхгүй байлгах, хошууны худалдааг хуульд заасан ёсоор явуулж, хяналт тавих болон харуулын газрын орчим худалдаа хийхийг эрс цаазлан хориглосон байдаг.

Монголын гаалийн албаны түүхэнд холбогдох сонирхолтой олон баримтууд Монгол Улсын Үндэсний архивын сан хөмрөгт хадгалагдаж байна. Гухайлбал,

Олноо өргөгдсөний хоёрдугаар оны зуны тэргүүн сарын шинийн 7-нд Богд хаанд доорх гурван яамнаас зарлиг гуйж айлтгасан нь. Үүнд: Гадаад хэргийг ерөнхийлөн шийтгэгч яам, Сангийн яам, Гаалийн яамнаас айлдсан нь “Гааль түрээс хямдхан хурааж, улсын хэрэглэхүй дор тус болохгүй нь манай Монгол улс ноднин жил, өвөл сар Тулгар төрөө байгуулснаас нааш худалдааны иргэдийг зүйл, зүйлээр нь нэгүйсэн өршөөж, хөнгөхөн хурааваас зохих гааль түрээсийг тэдний худалдааны иргэдийг гуйсан ёсоор дараа удаа алгуурласаар нэгэнт хагас жил илүү болсон нь одоо дахин алгуурлахуйд үнэхээр бэрхийн тул манай гадаадын зэрэг яамнаас тус улсын харъяат олон газар худалдах иргэдийн тээж авчирсан бараа зүйл жич: Улсын газраас худалдаалах авчрах мал, арьс, шир зүйлээс энэ удаа хөнгөвлөн авах тэнцэх үнэ 100 хувиас 5 хувь гааль хураах ба олон худалдааны иргэдийн хошуудын нутагт үржүүлэн одуулах малаас зохих үнэ бэлчээрийн гааль хураахаар дүрэм хэмжээг хянан тогтоож Богд хаанд айлтгажээ. Уг дүрэм нь “Олон иргэдийн худалдаанаас гааль хураах дүрэм” нэртэй бөгөөд дөрвөн анги 15 зүйлтэй ажээ. Үүнд:

1-р анги, 1-р зүйл: Монгол улсын харъяат олон газар худалдаалахаар ирэх уул газраас тээн авчирсан цай бараанаас 100 хувиас 5 хувь гааль хураах

2-р зүйл: Худалдааны иргэд тээн худалдах архины нэгэн зүйлд даацах үнийн 100 хувиас 10 хувийн гааль хураах (дүрэмд архины гааль нэг дахин байхаар заажээ)

3-р зүйл: Монголын гаалийн байгууллагаас үнэ тогтоож татвар хураасан үнэ бол уг барааг цаашид жижиглэн худалдаалах үнэ болох ёстой. Хэрэв дур мэдэн өөрчилсөн аваас шийтгэх

4-р зүйл: Иргэд нэгэнт дүрмийн ёсоор гааль хураалгасан бол өөр ямар ч газар очсон дахин гааль хураалгахгүй байх

2-р анги, 5-р зүйл: Аливаа худалдааны иргэд Монгол улсын харъяат олон газраас худалдан авчрах мал, арьс, шир, эвэр, заар, мод, хужир, алтны элс цулаа зэргээс 100 хувиас 5 хувь гааль хураах

6-р зүйл: Хөдөө, орон нутагт одоо худалдаа хийх Хятад иргэд нь аль ч газар очсон нутгийн тамгын газраас холгүй газарт нутаглан худалдаалж, гааль татварын хэргийг хянан байцааваас зохимжтой

7-р зүйл: Иргэд монгол нутгаас мал, түүхий эд зэрэг зүйлсийг худалдан авч хязгаар нэвтрүүлэхдээ цөм уг нутгийн хошуу тамгын газар мэдүүлж, харъяат гаалийн хороо буюу зохих албаны хүнд шалгуулж дүрмийн ёсоор гааль хураалгаж, зохих тэмдэгт бичиг олгосоны хойно хязгаараас гарч одвоос зохино

3-р анги, 8-р зүйл: Манай олон газар мал үржүүлэн байгаа Хятад иргэд жил бүр хоёр удаа бэлчээрийн гааль хурааваас зохилтой. Дүрэмд зааснаар жилд хоёр удаа бэлчээрийн гааль хураахыг заасан хэдий ч Олноо өргөгдсөний хоёрдугаар онд уг дүрэм анх үүсгэн шийтгэсэн тул гааль хураах хугацаа нэгэнт өнгөрч дараагийн намрын сүүл сард

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

ганц удаа хураасугай. Энэ жилээс хойш уул тогтсон дүрмийн ёсоор жил бүрийн хоёр удаа бэлчээрийн гааль хурасугай хэмээн нугалбар бичжээ.⁴

9-р зүйл: Гаалийн татварын хэмжээг тэмээ нэг бүрээс нэг лан, адуу, үхэр нэг бүрээс таван цэн, хонь, ямаа, нэг бүрээс хоёр цэн, хурга, ишиг тутмаас таван фун мөнгө хураах

4-р анги, 10-р зүйл: Монгол хүнд худалдааны иргэд өөрийн мал барааг биед нь хүлээлгэж, нэр зүүн галь нэвтрүүлэхийг оролдвоос хоёуланг нь хүндээр шийтгэмой. Мөн гаалийн хорооны албны иргэд өөрсдөө ов мэх хэрэглэн хөдөөний монгол хүний зоос мөнгийг мөлжин авахбол хүндээр цээрлэл үзүүлмой. Мөн энэ үед хар тамхи тариалах, оруулж ирэх явдал үлмж байсан тул дараах сэнхрүүлэн ухуулах бичгийг гаргасан байна. “Хар тамхи хэмээгч блвоос хамаг хортой бузар юм мөн тул үүнээс урагш Монгол газарт тарих, аливаа хүн татх, дотор газраас авчирч худалдаалах зэргийг цаазлан хорьсугай”⁵ гэжээ.

11,12-р зүйл: Гаалийн хэргийг мөчөөрхөн зөрчсөн этгээдийг нууцаар худалдаа хийсэн хэмээн үзэж гаалийн хураамжыг арав дахин нэмэгдүүлэн хурааж торгон шийтгээд, Монгол газар худалдалахыг зогсоож, уул нутагт нь үлдэн хөөж, олонд цээрлэл болгох,

13-р зүйл: Гаалийн албаны хүмүүс түшмэд нар гаалийн хэргийг үнэн цагаанаар хийж хянан байцааж чдвас шагнан, сайшаан хөхүүлмой

14-р зүйл: Гааль буруу хураалгасан буюу гаалаас зайлсхийсэн хүнийг гэрчлэн гаргасан хүнд гааль нэмэгдүүлэн торгосон 10 хувийн 5 хувийг шагнан өгөх тухай заажээ.

15-р зүйл: Үүээс дээш буй гаалийн дүрмийн дотор гүйцэлдээгүй зүйлийг ч цагаанаа дагаж нэмэн огтоосугай

Дээрх зүйлүүдд Монгол улсын үндэсний гаалийн албаас хураах гаалийн төрөл зүйлийг тодорхой болон гадаад, дотоодын худалдаачдаас хураах гаалийн төрөл, хэмжээ, шимтгэл, торгуулийн алаар тодорхой заажээ.

Мөн, гаалийн амнаас эрхэлсэн ажилдаа чин шударга, үнэнч зүтгэлээр ажиллаж, ажилдаа хариуцлагатай хандсан гаальчдыг шагнасан, шийтгэсэн талаарх баримт Монгол Улсын архивын сан өмрөгт хадгалагдан байна. Тухайлбал: Гааль хураах хэрэгт үнэн шийтгэсэн түшмэл, бичигч нарт шагнан, хөхүүлэхийг зарлиг ёсоор болгосныг хичээнгүйлэн дагаж, үүн хоёр аймгийн Эрдэнэшанздавын нарын учир бүгд ерөнхийлөн захирах зэрэг таван яаманд явуулан тушаах бичиг. “... Энэ жилийн зуны дунд сарын арван наймнаас эхэлж гааль хурааснаас нийт үнээр мөнгө хорин түм нэгэн мянган лан илүү хураав. Байцааваас уйд Чин улсын нийслэл хүрээнд суусан сайд нар гааль хураахад дөрвөн жил тутам ний арван найман түм лан илүү хураагаад Монгол хошуунд хоёр хувь олгуулж байсан. Чин улсын санд нийт арван гурван түмэн лан илүү оруулсан нь илэрхий байна. Манай улс долон сар нийт дүнээр хорин түмэн нэг мянга илүү лан гааль хураасны дотор Улиастай ба баян хоёр аймгаас хураасан нийт есөн мянга илүү лан Чин улсын дөрвөн жил хураасан гаалийн мөнгөний тооноос нэг түм илүү лан хураажээ. Энэ нь гаальчдын шаргуу, үнэнч зан чанартай салшгүй холбоотой учир шагнан хөхүүлбээс зохино”⁶ гэдгийг тавь яаманд илгээсэн бичигтээ дурдаж эдгээр хүмүүс анхны шагнал отог, жинсийг авсан байна.

Олноо өргөгдсний хоёрдугаар он 12-р сарын 29-нд доорхи нэр бүхий түшмэдийг шагнажээ.

1. Дэд зэрэг: Тогосын отог хадгалсан Дашдэлгэр
2. Гутгаар зэрг: Тогосын отог хадгалсан жинхэнэ түшмэл Цэрэнпунцаг
3. Гутгаар зэрг, Тогосын отог хадгалсан жинхэнэ түшмэл Дэлгэр
4. Дөтгөөр зээг: Тогосын отог хадгалсан Лувсандоной

⁴ УТТА. Фонд А.8.Д.1., X.,12

⁵ УТТА. Фонд А.8. Д.1.,X.,25

⁶ УТТА, Фонд А.8., Данс, ХН.342-344

5. Дөтгөөр зэрэг: Балсан
6. Дөтгөөр зэрэг: Омбо-Очир
7. Дөтгөөр зэрэг: Сүхбаатар
8. Тавдугаар зэрэг: Алтангэрэл нарт тэнгэрийн хишиг гуйж онцгой гавъяа бүхий тул онцгой хишиг хүртээн цөмд отогтойд нь өөр, өөрийн нэгжээд зэрэг нэмж, отоггүйд нь хөх отог шагнан хүртээжээ.⁷

Мөн үүний хамт ажилдаа хариуцлагагүй ажилтнуудыг торгон шийтгэдэг байжээ. Гаалийн дүрэмд зааснаар 10 хувь торгодог байжээ.

Мөн хятад худалдаачид өөрийн бараа таваарыг нуун далдалсан бол торгон шийтгэдэг байжээ. Гадаад яаманд ирүүлсэн Нийслэл хүрээний баруун гаалийн хорооноос түшмэл Мээрэн, Омбонэрэн нарын бичигт: ... Энэ оны наймдугаар сард гааль огцорохыг хичээж, гааль хураах чухал ажлыг даран далдалсан иргэдийг байцаан гаргаад уул иргэдийг торгож шийтгэсэн мөнгөний хамтаар бичиж ирүүлсэн байх ба Ни хуа Сен хэмээх пүүсээс нуун дарсан тарваганы арьс 98 ширхэг олж 48 цаасаар шийтгэсэн байна.

Мөн Сэцэн хан аймгийн Мэргэн засгийн тамгаас иргэдийн гааль хураахаас буруу бодож илүү, дутуу хураасан тухай туслагч тайж Дугаржав энэ жил зуны цагаас эхлэн хураасан бүгд гаалийн мөнгийг намар гаалийн яаманд хүргүүлэхэд уул иргэдээс хураасан гаалийн мөнгөнөөс 15 лан 6 цэн илүү үлдээсэн учир уг гаалийг хураалцаж эхлэн бичиж байсан бичээч учрыг үл олон мэдүүлсэн байдаг. Мөн иргэдээс хураасан татвараас гаальчид илүү мөнгийг хураан авч өөртөө завшин байсан тухай бүр нь илрүүлж, арга хэмжээ авч, төрийн ажилтаний цэгц шударга, үнэнч ажиллах журмыг чандлан мөрдүүлж, сахиулдаг байсан ажээ.

Abstract

"In 1912, the Mongolian government headed by Bogd Khaan has formed its Ministry of Customs. This organization was of vital importance to the financial and properties' policy of the new state. The Ministry introduced new special regulations and headed all activities related to their implementation."

⁷ УТТА, Фонд.А.8. Данс.1., ХН.347